

**2023 ОНЫ 07 ДУГААР САРЫН 19-НИЙ ӨДРИЙН ДҮҮРГИЙН УДИРДАХ
АЖИЛТНЫ ШУУРХАЙ ЗӨВЛӨГӨӨНД ЗАСАГ ДАРГЫН ОРЛОГЧООС
ӨГСӨН ҮҮРЭГ ДААЛГАВАР**

Дүүргийн шуурхайн үүргийн биелэлтийг Arial-12 фонтоор бичиж, 2023 оны 07 дугаар сарын 24-ний “Даваа” гарагийн 12:00 цагт багтаан e-doc системээр албан бичгээр ирүүлж, Төрийн захиргааны удирдлагын хэлтэс (ERP Б.Одбаяр)-т файлаар ирүүлнэ үү. Хугацаа хэтэрсэн, албан бичгээр ирүүлээгүй тохиолдолд биелэлт ирүүлээгүйд тооцно.

№	Өгсөн үүрэг даалгавар	Хариуцах эзэн
НИЙСЛЭЛИЙН ЗАСАГ ДАРГА БОЛОН ДҮҮРГИЙН ЗДО-оос ӨГСӨН ҮҮРЭГ ДААЛГАВАР		
2023-2024 ОНЫ ӨВӨЛЖИЛТИЙН БЭЛТГЭЛ ХАНГАХ АЖЛЫН ХҮРЭЭНД		
1	Өвөлжилтийн бэлтгэл хангах ажлын хүрээнд инженерийн шугам сүлжээ, авто зам, тохижилт, ногоон байгууламжийн ажлын төлөвлөгөөний хэрэгжилтийг эрчимжүүлж ажиллах.	ТХҮХ, Дэд бүтцийн байгуулагууд, Багахангай тохижилт, Багахангай гэрэлтүүлэг, ногоон байгууламж ОНӨААТҮГ-ууд
2	Өвөлжилтийн үед хүндрэл гарч болзошгүй сургууль, цэцэрлэг, эмнэлэг, халаалтын зуух, барилга байгууламжийн цахилгаан, дулаан, шугам сүлжээний засварын ажилд шаардагдах хөрөнгө оруулалтын тооцоо, судалгааг гарган, удирдлагад танилцуулж, холбогдох байгууллагад саналаа хүргүүлэх.	ТХҮХ, дэд бүтцийн байгууллагууд, Боловсролын хэлтэс, ЭМТ,
3	Нийслэлийн Засаг даргын 2023 оны “Хөрөнгө оруулалт, бүтээн байгуулалтын ажлыг эрчимжүүлэх талаар авах зарим арга хэмжээний тухай” А/378 дугаар захирамжийн хэрэгжилтийг эрчимжүүлэх хүрээнд төсөв мөнгө шийдэгдсэн ААНБ-ууд өөрт харьяалагдсан ажлын даалгаврыг 2023.07.19-ний өдөрт багтаан ирүүлэх.	СТСХ, ХААА, Холбогдох ААНБ-ууд
4	Ерөнхий боловсролын сургууль, цэцэрлэг, эмнэлгийн барилга байгууламжийн болон инженерийн шугам сүлжээнд хийгдэх урсгал засварын ажлуудыг эрчимжүүлж ажиллах.	Боловсролын хэлтэс, ХЦС, 44, 207,183 дугаар цэцэрлэгүүд, ЭМТ
ЦАГ ҮЕИЙН АСУУДЛЫН ХҮРЭЭНД		
5	Нийслэлийн Засаг даргын 2023 оны “Үерийн хор уршгийг арилгах зарим арга хэмжээний тухай” А/806 дугаар захирамжийн хэрэгжилтийг ханган болзошгүй аюулаас урьдчилан сэргийлэх хүрээнд хүүхдийг тогтоол усанд тоглуулахгүй байлгахад эцэг эхчүүд хараа хяналтаа сайжруулах шаардлагатайг анхууруулж ажиллах.	ОБХ, Хороод,
6	Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн хууль тогтоомж, стандартын шаардлагыг мөрдүүлж, хэрэгжилтэд хяналт тавьж ажиллах.	Дэд бүтцийн байгууллагууд, холбогдох бусад байгууллагууд
7	Дүүргийн баяр наадмыг зохион байгуулах “Ажлын хэсэг”-т илүү цагаар ажилласны урамшуулал олгох боломж нөхцлийн талаар судалж удирдлагад танилцуулах.	ТЗУХ
8	Гэр хорооллын айл өрхүүдэд өөрсдийн хөрөнгөөр ариутгалын бодисыг худалдан авч амьдрах орчноо аюулгүй байлгах, хөрсний бохирдол, халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх зорилгоор халдаргүйтгэл хийх талаар мэдээлэл хүргэх.	Хороод